

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, 18.5 дахь заалт болон “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалтуудын дагуу гаргасан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 298 дугаар тушаалыг үндэслэн “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /УАГ-САГ/2015/06-СТА-ГАК-ТӨХЭ / аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон явцын аудитын талбар дээрх ажлыг 2014 оны 11 дүгээр сарын 10-аас 17-ны өдрүүдэд, жилийн эцсийн аудитын талбар дээрх ажлыг 2015 оны 02 дугаар сарын 23-аас 28-ны өдрүүдэд Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв. /ТАБ-СТА-А-1/

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2014 оны санхүүгийн тайланг 2015 оны 03 дугаар сарын 06-нд Үндэсний аудитын газарт хүргүүлэв.

Үндэсний аудитын газар аудитыг 2015 оны 03 дугаар сарын 06-наас 2015 оны 03 дугаар сарын 13-ны хооронд хянаж, аудитын тайланг 2015 оны 03 дугаар сарын 16-нд “Шивээ-Овоо” ТӨХК-ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Шивээ-Овоо” ТӨХК-ын төсвийн захирагч нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Компанийн тухай”, “Эрчим хүчний тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Шивээ-Овоо” ТӨХК нь байгаль орчинд ээлтэй, аюулгүй үйлдвэрлэл, өндөр бүтээмж бүхий уул уурхайн салбарын жишиг компани байхыг эрмэлзэж эрхэм зорилгоо болгон төвийн эрчим хүчний систем болон орон нутгийн дулааны станцуудыг эрчим хүчний нүүрсээр тасралтгүй найдвартай хангах үүрэг хүлээн ажиллаж байна.

“Шивээ-Овоо” ХК нь анх 1990 онд байгуулагдаж Монгол улсын дотоодын нүүрсний хэрэглээний 28.3%-ийг нийлүүлж, Монгол улсын Эрчим хүчний 70.0%-ийг дангаараа цахилгаан, дулаан үйлдвэрлэдэг “ДЦС-4” ТӨХК-ийн нүүрсний хэрэглээний 50.0%-ийг хангаж байна.

Тус байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь хөрс хуулах, хүрэн нүүрс олборлож нийлүүлэх юм. Бүтээгдэхүүний үнийг төрөөс зохицуулдаг, өртгөөс бага үнээр борлуулалт хийгддэг, борлуулалтын 93 орчим хувь нь нэг худалдан авагч буюу “ДЦС-4” ТӨХК-д нийлүүлэгддэг, бусад борлуулалтыг жижиг аж ахуйн нэгжүүдэд хийдэг. 2014 онд үйлдвэрлэлийн бүрэн хүчин чадалд хүргэн 2.0 сая тонн нүүрс олборлон борлуулсан. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг хувьчлах жагсаалтад “Шивээ-Овоо” ТӨХК орсон болно.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан, мөн shivee-ovoo.mn вебсайтад байгууллагын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллүүд тавигдсан байгаа болно.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудитыг гүйцэтгэхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 53-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Шивээ-Овоо” ТӨХК нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар судалгаа авч түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо тусгайлан шаардлагагүй гэж дүгнэн аудитыг мэдээллийн технологийн ажилтны оролцоогүйгээр гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг компанийн ажилтнуудын боловсруулсан уулын ажлын мэдээ, уулын техникийн мэдээлэлтэй уялдаа бүхий Мoney програм, мөн “Даянсофт” ХХК-ийн үндсэн хөрөнгийн модулыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу бэлтгэн тайлагнасан байна.

Материаллаг байдал:

Аудитын материаллаг байдлыг тооцоходоо 2014 оны 12 дугаар сарын 31-ээрх нийт борлуулалт, нийт зарлага, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгийн сууриудаас нийт зардлыг суурь болгон авч төлөвлөлтөөр 357.4 сая төгрөг гэж тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй хэвээр хадгалсан.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Шивээ-Овоо” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон. Дотоод хяналтын үйл ажиллагааны тайлантай танилцахад үйл ажиллагааны чиглэл тус бүрт хийгдсэн ажлуудыг тайлагнасан байлаа.

Төлөвлөсөн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2014 онд “Шивээ-Овоо” ТӨХК нь 2,000.0 мянган тонн нүүрс олборлож борлуулахаар төлөвлөсөн боловч 1,939.1 мянган тонн нүүрс олборлож 2,013.7 мянган тонн нүүрс борлуулсан байна. Нүүрс олборлолтын тоо хэмжээний төлөвлөгөө 97.0%, харин нүүрс борлуулалтын тоо хэмжээний төлөвлөгөө 100.7%-ийн биелэлттэй байна.

2014 онд 2,000.0 мянган тонн нүүрс борлуулж 36,481,200.0 мянган төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 2,013.7 мянган тонн нүүрс борлуулж 36,163,584.5 мянган төгрөгийн борлуулалт хийж борлуулалтын төлөвлөгөөг 99.1%-иар

биелүүлж ажилласан байна. Нэг тонн нүүрсний борлуулах дундаж үнийг 18,240.60 төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр нэг тонн нүүрсний борлуулсан дундаж үнэ 17,959.10 төгрөг байсан байна. Тоо хэмжээгээр төлөвлөснөөс илүү нийлүүлсэн боловч үнийн зөрүү буюу илчлэгийн зөрүүгээс орлого алдсаныг харуулж байна.

Төлөвлөгөөгөөр 8,250.0 мянган метр куб хөрс хуулалт хийх байсан боловч гүйцэтгэлээр 6,774.8 мянган метр куб хөрс хуулж хөрс хуулалтын төлөвлөгөө 82.1%-ийн биелэлттэй байна.

Төлөвлөгөөгөөр татвар төлөхийн өмнөх ашиг (7,183,346.5) мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөж гүйцэтгэлээр (4,993,092.2) мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

“Шивээ-Овоо” ТӨХК нь 1 тонн нүүрсний олборлолтын өртгийг 20,801.60 төгрөгөөр төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 19,533.30 төгрөг, 1 м.куб уулын цулын өртгийг 3,475.50 төгрөгөөр төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 3,359.80 төгрөгөөр тооцогдсон нь төлөвлөсөн зардлыг хэмнэж ажилласаныг илэрхийлж байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуульд “байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэнэ” гэж заасны дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байлгах, түүнд олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх зорилгоор shivee-ovoo.mn сайтад “шилэн данс” гэсэн цэс нэмж мэдээллэл байршуулан ажиллаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 53 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Эдгээр сорилуудаар дараах алдаа зөрчил илэрсэн байна.

Үүнд:

- Кассын гэнэтийн тооллогоор 20,022 төгрөг дутагдсан,
- Хасбанкны шугамын зээлийн харилцах дансанд 100.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гэж тайлагнасан боловч тайлангийн өдөр зээлд татагдаж төлөгдсөн байсныг бүртгэлд тусгаагүй,
- Бараа материалын түүвэрчилсэн тооллогоор 35.0 сая төгрөгийн 566-13-41002 тоот Converter биетээр байгаагүй, түр шаардахаар зарлагдсан байсан. Түр шаардах хуудас ирүүлснийг хянаж үзэхэд гарын үсэг дутуу байсан,
- Нягтлан бодох бүртгэлийн 1554 тоот сэлбэгийн дансанд орлого авсан хөрөнгийг 2004 тоот үндсэн хөрөнгө дансанд давхар орлого авч авлагын дүнг 49.5 сая төгрөгөөр бууруулсан,
- Бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл өртөг 583.0 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн,

- Орлогын тайланд 5.8 тэрбум төгрөгийн Борлуулалтын болон маркетингийн зардлыг тусгайлан харуулаагүй өртөгт оруулан тайлагнасан,
- Програмын Орлогын тайлан хэвлэсэн Орлогын тайлангаас зардлын дүн нь 6.8 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн,
- Японы зээлийн эх үүсвэрийн тооцоог Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 100%-ийн эзэмшилтэй “Шивээ сервис” ХХК-ийн санхүүгийн тайланг нэгтгээгүй байлаа.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого, зардал, цалингийн зардал, томилолт, шуудан холбоо зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын мөнгөн хөрөнгийн 75 хувь, нийт орлого, зардлын 75 хувь, нийт хөрөнгийн 80 хувийг хамарсан болно.

“Шивээ-Овоо” ТӨХК нь 2014 онд өмнөх аудитын зөвлөмжийн дагуу үйлдвэрлэлд оруулсан боловч хараахан бэлэн бүтээгдэхүүн болоогүй байгаа зардлыг хуримтлуулан тооцож “Дуусаагүй үйлдвэрлэл”-ийн эхний үлдэгдэл болгон 1,806,250.0 мянган төгрөгийн залруулах гүйлгээ хийсэн бөгөөд энэхүү ажил гүйлгээ нь өмчийн өөрчлөлтийн тайланд тусгагдсан байгаа болно.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа зөрчил илэрсэн байна.

Үүнд:

1. Хасбанкны шугамын зээлийн харилцах дансанд 100.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гэж тайлагнасан боловч тайлангийн өдөр зээлд татагдаж төлөгдсөн байсныг бүртгэлд тусгаагүй,

Шийдвэрлэсэн: Богино хугацаат зээлийн өглөгийг бууруулсан залруулга хийгдсэн,

2. Бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл өртөг 583.0 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн,

Шийдвэрлэсэн: ББӨртөгийг бууруулан Бэлэн бүтээгдэхүүний өртөг өсгөн залруулсан, мөн энэхүү тооцооллын явцад нүүрсний нэгжийн өртөгт цахилгааны зардлаар залруулга хийгдсэн,

3. Орлогын тайланд 5.8 тэрбум төгрөгийн Борлуулалтын болон маркетингийн зардлыг тусгайлан харуулаагүй өртөгт оруулан тайлагнасан байна,

Шийдвэрлэсэн: ББӨртгийг бууруулан Борлуулалтын болон маркетингийн зардлыг орлогын тайланд тусгайлан харуулсан,

4. 100%-ийн эзэмшилтэй “Шивээ сервис” ХХК-ийн санхүүгийн тайланг нэгтгээгүй,

Шийдвэрлэсэн: 2015 онд ТУЗ-д танилцуулан буцаан нэгтгэх эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр төлөвлөж байгаа тул залруулаагүй, аудитын тайланд зөвлөмж бичигдэх,

5. Японы эзэлийн эх үүсвэрийн тооцоог Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулаагүй,

Шийдвэрлэсэн: Тооцоо нийлж баталгаажуулах.

Материалдаг бус дараах зөрчил илэрсэн байна.

Үүнд:

1. Кассын гэнэтийн тооллогоор 20,022 төгрөг дутагдсан,

Шийдвэрлэсэн: Дутагдлыг төлүүлэх,

2. Бараа материалын түүвэрчилсэн тооллогоор 35.0 сая төгрөгийн 566-13-41002 тоот Converter биетээр байгаагүй, түр шаардахаар зарлагдсан байсан. Түр шаардах хуудас ирүүлснийг хянаж үзэхэд гарын үсэг дутуу байсан,

Шийдвэрлэсэн: Баримтыг тухай бүр бүрдүүлж, шаардлагатай гарын үсгийг тухай бүр зуруулж хэвшихийг анхааруулав,

3. Програмын Орлогын тайлан хэвлэсэн Орлогын тайлангаас зардлын дүн нь 6.8 сая төгрөгөөр илүү байсан,

Шийдвэрлэсэн: Санхүүгийн програм тохируулагдаагүй байсан зардлын дансыг програмд тохируулж залруулсан,

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар: Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн 1554 тоот сэлбэгийн дансанд орлого авсан хөрөнгийг 2004 тоот үндсэн хөрөнгө дансанд давхар орлого авч авлагын дүнг 49.5 сая төгрөгөөр бууруулсан. Асуудлын бүртгэлийг танилцуулах үед залруулахаар шийдвэрлэсэн боловч залруулж ирүүлсэн санхүүгийн тайланд залруулаагүй байсан тул 2015 онд залруулахыг үүрэг болгосон.

Мөн Японы зээлийн эх үүсвэрийн тооцоог Сангийн яамтай тооцоо нийлэхэд ханшийн зөрүүгээс 366.0 сая төгрөгийн зөрүүтэй байгаа тооцоо нийлсэн акт ирүүлсэн.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Тус компанийн үндсэн бүтээгдэхүүн болох хүрэн нүүрсний борлуулалтын үндсэн худалдан авагч “ДЦС-4” ТӨХК нь худалдан авсан нүүрснийхээ үнийг бүрэн төлөхгүй байгаагаас авлага их хэмжээгээр өсч байгаа, мөн хүрэн нүүрсний үнийг төрөөс зохицуулалт хийж “бага” байлгах бодлого хэрэгжүүлж байгаагаас шалтгаалан компани алдагдалтай ажилласаар ирсэн.

“Эрчим хүчний салбарыг зах зээлийн харьцаанд бүрэн шилжүүлэх, үнэ чөлөөлөх тухай” УИХ-ын 2010 оны 12 сарын 72 дугаар тогтоол батлагдсан. Уг тогтоолоор эрчим хүчний үнийг 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн эрчим хүчний үнэ тариф бүрэн чөлөөлөгдсөн байхаар заасан, гэвч тодорхой нөхцөл байдлын улмаас энэ асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Эрчим хүчний зохицуулах хорооны шийдвэрээр 2014 оны 07 дугаар сараас эрчим хүчний үнийг үе шаттайгаар нэмэгдүүлж эхэлж байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 6,574,640.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 6,490,140.0 мянган төгрөгийн зөрчилд залруулга хийлгэж санхүүгийн тайланд тусгасан ба 84,500.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Мөн Японы зээлийн эх үүсвэрийн тооцоог Сангийн яамтай тооцоо нийлэхэд 366.0 сая төгрөгийн зөрүүтэй байгааг дахин нягтлаж тохируулах талаар 1 албан шаардлага өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжялт:

2013 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Балхан-Аудит” ХХК гүйцэтгэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн ба уг аудитаар 6 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн биелэлт 90 хувьтай байна.